Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
201 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Нөхөн үржихүй, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж, лабораторийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй.

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжилт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зорилтод бүлгийн иргэдэд хүргэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг ........
2019 оны 11 сарын 11 өдөр.

Албан тушаалын зорилт:

1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах.
2. Хүн амд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан салбар хоорондын уялдаа холбоог хангах, жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.
3. Өсвөр үе, залуучуудад зориулсан тусламж үйлчилгээний ээлтэй орчин бүрдүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.
4. Хууль тогтоомжизаасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах бодлогын болон хууль эрх зүйн орчнûг боловсронгуй болгох асуудлыг хэрэгжүүлэх, тайлагнах; | Хэрэгжилтийн хувиар, | Г |
| | 2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнг тооцох, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж байгаа стандарт, оношилгоо эмчилгээний удирдамж, заавар, журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, нэгдсэн арга зүй удирдлагаар хангах, үр дүнг тооцох; | Стандарт удирдамжийг хэрэгжилтийн хувиар, | Г |
| | 3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гэр бүл төлөвлөлтийг хөгжүүлэн, жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэн, жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулах, эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох; | Үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгээр, | Г |
| | 4. Нөхөн үржихүйн чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтнийг холбогдох тушаал шийдвэр, эрх | Хэрэгжилтийн үр дүнгээр, | Г |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | зүйн актаар хanган ажиллах;<br>5. Нийгмийн эрүүл мэндийн асуудалд эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах үйл ажиллагааг төлөвлөлтөнд тусгах, хэрэгжилтийг хангах , үр дүнг тооцох. | Эрчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлтээр, | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн тэгш байдал, хүчирхийллийн асуудлаар хөтөлбөр, төсөл, үндэсний стратегийг хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд үйл ажиллагааг мэргэшил, арга зүй, удирдлагаар хангах; | Хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хувиар, | Г |
| | 2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн тэгш байдлын асуудал, хүйсээр ялгаварласан хүчирхийллийн асуудлаар олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй төслийг үндэсний хөтөлбөр, стратегитай уялдуулах; | Хөтөлбөр стратегийг хэрэгжилтийн хувиар, | Г |
| | 3. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерийн тэгш байдлын асуудал, хүйсээр ялгаварласан хүчирхийллийн асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх. | Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч багш бэлтгэх, сургуулийн эмч нарыг сургалт мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; | Зохион байгуулсан сургалтын тоогоор, | Г |
| | 2. “Залуу эмч клуб”-ын үйл ажиллагаа идэвхижүүлж, мэргэжил арга зүйгээр хангах; | Зохион байгуулсан сургалтын тоогоор, | Т, Г |
| | 3. “Ирээдүйн босго төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, тусламж үйлчилгээний ээлтэй орчин бүрдүүлэх. | Тусламж үйлчилгээний орчноор, | Г |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, тайлагнах; | Үүрэг даалгаврын хэрэгжилтээр, | Г |
| | 2. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөж ажиллах; | Стандартыг хэрэгжилтийн хувиар, | Г |
| | 3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох; | Оролцсон арга хэмжээний тоогоор, | Г |
| | 4. Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж, Авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; | Ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Г |
| | 5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна. | Хэрэгжилтийн хувиар, | Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | Эрүүл мэнд /091/. | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Дэс болон туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх ;<br>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- төрийн албан хаагчийн ёс зүй, хэм хэмжээг сахих;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх |

| | | |
|---|---|---|
| | | чадвартай байх;<br>- бүтээлч санаачлагатай байх;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- нээлттэй шударга байх;<br>- бусад. |
| | Бусад | - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;<br>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавих. |

**IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>

Эрүүл мэндийн газрын дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект : |
|---|---|
| Байхгүй. | - Эрүүл мэндийн яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,<br>- Аймгийн Засаг даргын орлогч,<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,<br>- Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, |

| | |
|---|---|
| | - Иргэн, хуулийн этгээд. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА<br>........................................ Н.ОЮУНТУЯА<br>20.... оны ..... дугаар сарын .....-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: ...19...10... 30<br>Дугаар: .......201....... |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: ...............

Дугаар: ...............

(тамга/тэмдэг)

ДАРГА ........................................... Д.ШИВААННҮРДЭВ

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ